



БАЯНХОНГОР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



СТАТИСТИКИЙН

ТАНИЛЦУУЛГА

04/2017

Баянхонгор аймгийн эдийн
засаг, нийгмийн байдал

Энэ удаагийн дугаарыг эрхлэн гаргасан
хэлтсийн мэргэжилтэн Б.Дэлгэрмаа

**ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН
2017 ОНЫ 04 САРЫН ТАНИЛЦУУЛГА**





ОРОН НУТГИЙН ОРЛОГО, БАНК

2017 оны эхний 4 сарын байдлаар аймгийн төсвийн орлогын дүн 2588.4 сая төгрөг болсон ба нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг Галуут, Эрдэнэцогт, Баян-Овоо, Баян-Өндөр, Баянцагаан, Баацагаан, Бууцагаан сумууд давуулан биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: НӨАТатвар 66.2 сая төгрөг, агаарын бохирдол/авто/ 12.6 сая төгрөг, ҮХЭХ-ийн татвар 4.0 сая төгрөг, газрын төлбөр 6.3 сая төгрөг, ҮХЭХ борлуулсны 0.6 сая төгрөг, орон нутгийн зам ашигласны хураамж 2.2 сая төгрөг, хог хаягдлын хураамж 19.0 сая төгрөг, нохойны татвар 1.4 сая төгрөг, бууны татвар 3.9 сая төгрөгөөр тус тус тасарч, ААНБ-ын орлогын татвар 58.6 сая төгрөг, агаарын бохирдол /нүүрс/ 9.9 сая төгрөг, ашигт малтмал 41.7 сая төгрөг, цалин хөлс түүнтэй адилтгах орлого/суутган-1/ 80.3 сая төгрөг, АТӨЯХ-ийн татвар 28.6 сая төгрөг, ИОТТХ 1.4 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 25.3 сая төгрөг, газрын дуудлага худалдаа 0.6 сая төгрөг, ус ашигласны төлбөр 63.5 сая төгрөг, түгээмэл тархацтай АМАТ 0.9 сая төгрөгөөр тус тус давуулан биелэлээ.

Нийт орлогод ААНБ-н орлогын албан татвар 4.0 хувь, нэмүү өртгийн албан татвар 3.8 хувь, ЦХТА орлого 59.5 хувь, авто тээвэр өөрөө авагч хэрэгслийн татвар 2.8 хувь, хүү торгууль 9.0 хувь бусад төлбөр хураамж 20.9 хувийг эзэлж байна.

2017 оны 4 сарын байдлаар иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 66178.2 сая төгрөг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 130520.9 сая төгрөгт хүрчээ. Чанаргүй зээл 3373.2 сая төгрөгт хүрсэн нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.5 хувийг эзэлж байна.





ЭРҮҮЛ МЭНД



2017 оны эхний 4 сарын байдлаар аймгийн хэмжээнд 592 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 55 төрөлтөөр буурсан байна. Нийт төрсөн эхийн 87.5 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, сум дундын, сумын эмнэлэгт 12.5 хувь нь төржээ. Нийт төрсөн 592 хүүхдийн 4 нь гэртээ мэндэлжээ.

0-1 настай хүүхдийн эндэгдэл 13, 0-16 насны эндэгдэл 18 гарсан байна.

Эхний 4 сарын байдлаар архаг болон цочмог халдварт өвчний гаралтыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад салхин цэцэг 45, тэмбүү 76, хүйтэн 34, арьсны мөөгөнцөр 16, гахай хавдар 1, сүрьеэ 12, суулгалт халдвар 7, трихоминиаз 145, гар хөл амны өвчин 5 тохиолдлоор тус тус гарсан байна.

Аймгийн хэмжээнд эхний 4 сарын байдлаар нас баралтын 151 тохиолдол бүртгэгдсэний 26.5 хувь нь эмнэлэгт нас барснаас 8.6 хувь нь хоног болоогүй нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс 2.2 хувиар өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага өнгөрсөн оны эхний 4 сард 6193 байсан бол энэ оны эхний 4 сарын байдлаар 5612 болж 581 дуудлага буюу 9.4 хувиар буурсан байна.



АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд 2017 оны эхний 4 сард оны үнээр 2.6 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулсан нь өнгөрсөн оныхоос 19.3 хувиар илүү байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 547.3 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 22.3 хувиар илүү байна.

Нийт үйлдвэрлэлтийн 61.6 хувийг дулаан үйлдвэрлэл, 18.8 хувийг уул уурхайн олборлох үйлдвэр, 10.2 хувийг усан хангамж, 7.8 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 1.2 хувийг гутал хувцасны, 0.4 хувийг хэвлэлийн үйлдвэрлэл эзэлж байна.

Гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал талх 9.5 хувиар, түгээсэн цэвэр ус 44 хувиар, дулаан үйлдвэрлэл 12.6 хувиар тус тус өссөн бол нүүрс 34.5 хувиар, нарийн боов 26.4 хувиар тус тус буурсан байна.



НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

2017 оны эхний 4 сард тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэрт 8322.7 сая төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 1790.3 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 604.3 сая төгрөг, цэргийн тэтгэвэрт 207.0 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 9.1 сая төгрөг, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжид 297.7 сая төгрөг, оршуулгын тэтгэмжид 123.0 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэрт 22.4 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 6.9 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 174.6 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас эмчилгээний эмийн зардалд 1099.8 сая төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөд 227.7 сая төгрөг тус тус олгожээ.

Нийгмийн халамжийн сангаас 2017 оны эхний 4 сард 1917 хүнд 1042.8 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй 2440 эхчүүдэд 301.4 сая төгрөг, алдарт эхийн одонтой 7082 эхчүүдэд 963.5 сая төгрөг, алдар цолтой 15 ахмадуудад 8.9 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн бол Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт, тусламж 368 хүн 71.3 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 231 хүн 34.0 сая төгрөг тус тус зарцуулсан байна.



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 4 сарын эцэст 1267 болж, бүртгэлтэй ажилгүй иргэдийн 57.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзэхэд 0.6 хувь нь магистр, доктор, 22.8 хувь нь дипломын, 5.3 хувь нь тусгай мэргэжлийн, 7.1 хувь нь техникийн мэргэжлийн, 41.0 хувь нь бүрэн дунд, 14.8 хувь нь бүрэн бус дунд, 6.6 хувь нь бага боловсролтой, 1.8 хувь нь боловсролгүй хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг нь насны бүлгээр нь судлахад бүртгэлтэй ажилгүй иргэдийн 15.6 хувийг 15-24 насныхан, 40.1 хувийг 25-34 насныхан, 22.7 хувийг 35-44 насныхан, 21.2 хувийг 45-59 насныхан, 0,4 хувийг 60 ба түүнээс дээш насныхан эзэлж байна.

Эхний 4 сард бүртгэлтэй ажилгүй иргэдээс 174 хүн ажилд зуучлагдан орсоны 59.2 хувь нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт, боловсролын салбарт 4 хувь, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн салбарт 2.9 хувь, 6.9 хувь нь үйлчилгээний бусад

үйл ажиллагааны салбарт, 15.5 хувь нь ХАА, ойн аж ахуй, ан агнуурын салбарт, 1.7 хувь нь боловсруулах үйлдвэрт, 3.5 хувь нь цахилгаан, хий, уур агааржуулалтын салбарт, 2.9 хувь нь барилгын салбарт, 1.7 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, 1.7 хувь нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт ажилд зуучлагдан оржээ.




ГЭМТ ХЭРЭГ

2017 оны эхний 4 сард аймгийн хэмжээнд нийт 147 хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 28 нэгжээр буюу 23.5 хувиар өссөн. Хэргийн илрүүлэлт 75.6 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16,9 пунктээр өсчээ. Хэргийн гаралт 7 суманд буурч, 11 суманд өсөж, 1 суманд ижил түвшинд, 1 суманд хэрэг бүртгэгдээгүй байна. Гэмт хэрэгт 164 хүн холбогдон шалгагдсан ба үүнээс 14-17 насны 17, 18-с дээш насны 147 хүн байна. Гэмт хэргийн улмаас 157 иргэн, байгууллага хохирч 7 хүн нас барж, 76 хүн гэмтсэн байна. Нийт 254.3 сая төгрөгийн хохирол учирснаас 186.7 сая төгрөгийг төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 73.4 хувьтай байна.

Хүний амь нэг нэгжээр буюу 33.3 хувь, өмчийн хулгай 1 нэгжээр буюу 2 хувь, малын хулгай 2 нэгжээр буюу 11.2 хувь, хувийн өмчийн хулгай 3 нэгжээр буюу 10 хувь, бусад гэмт хэрэг 3 нэгжээр буюу 20 хувь тус тус буурсан бол золгүй учрал 1 нэгжээр буюу 100 хувь, бусдын бие мах бодид гэмтэл учруулах 13 нэгжээр буюу 32.5 хувь, тээврийн хэрэгслийн хулгай 4 нэгжээр буюу 80 хувь, хүчин 1 нэгжээр буюу 100 хувь, дээрэм 2 нэгжээр буюу 100 хувь, залилан 6 нэгжээр буюу 6 дахин, танхай 7 нэгжээр буюу 3.7 дахин хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 3 нэгжээр буюу 100 хувь тус тус өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал нь хөнгөн гэмт хэрэг 68 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 21.4 хувиар, хүндэвтэр гэмт хэрэг 64 бүртгэгдэж 12.3 хувиар, хүнд гэмт хэрэг 13 бүртгэгдэж 4 дахин өссөн бол онц хүнд гэмт хэрэг 2 бүртгэгдэж 66.7 хувиар буурчээ.





ХӨДӨӨ АЖ АХУЙ

5 дугаар сарын 1-ний байдлаар оны эхний хээлтэгч малын 69.3 хувь нь буюу 1206.7 мянган эх мал төллөж гарсан төлийн 99.4 хувь нь буюу 1199.9 мянган төл бойжиж байна. Төл бойжилтыг малын төрлөөр үзвэл гарсан ботгоны 99.5 хувь, унаганы 98.3 хувь, тугалын 98.8 хувь, хурганы 99.5 хувь, ишигний 99.3 нь бойжиж байна. Сумдаас Баацагаан, Баянлиг, Баянцагаан, Богд, Бөмбөгөр, Бууцагаан, Гурванбулаг, Хүрээмарал сумд гарсан төлөө 99.0-100.0 хувиар бойжуулж байна.

Өнгөрсөн оны мөн үед аймгийн дүнгээр оны эхний төллөх эх малын 63.6 хувь нь төллөж, бойжиж байгаа төл 98.0 хувь байсан байна.

5 дугаар сарын 1-ний байдлаар оны эхний нийт малын 0.2 хувь буюу 9980 толгой мал том малын зүй бусын хорогдлоор хорогджээ. Нийт хорогдсон малын 0.1 хувийг тэмээ, 4.7 хувь нь адуу, 9.4 хувийг үхэр, 28.5 хувийг хонь, 57.3 хувийг ямааны хорогдол эзэлж байна. Сумдаас Баянговь, Баянхонгор, Баян-Овоо, Богд, Жаргалант, Өлзийт, Эрдэнэцогт сумдын оны эхний малын 0.4-0.7 хувь нь, бусад сумдын малын 0.0-0.3 хувь нь хорогдсон дүнтэй байна



ҮНЭ ТАРИФ

2017 оны 4 дүгээр сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарынхаас 2.1 хувиар, 2016 оны 12 сарынхаас 7.2 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 4.7 хувиар тус тус өссөн байна. Өзгөрсөн бүтээгдэхүүн, огаар ус 2017 ий 04 дүгээр сард өөр өөрөөр 4.0 хувиар, хувцас, бөс бараа, гутал 0.3 хувиар, гэр ахуйн тавилга 1.2 хувиар, тээврийн үйлчилгээ 5.4 хувиар, бусад бараа үйлчилгээ 0.5 хувиар өсч, согтууруулах ундаа, тамхи 0.5 хувиар, орон сууц, ус цахилгаан, түлш 0.2 хувиар буурсан нь өөрөөр 2.1 хувиар өсөхөд өөрөөр өөрөөр.

Тухайлбал: Өмнөх сарынхаас үхрийн мах, хонины мах, ямааны мах, сүү, ааруул, хавар, намрын хүрэм, гутал зэргийн үнэ 2.7-25 хувиар нэмэгдсэн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, 2017 оны 4 дүгээр сард

Үзүүлэлт	2017 IV	2017 IV	2017 IV
	2016 IV	2016 XII	2017 III
	Хувь		
Ерөнхий индекс	104.7	107.2	102.1
Хүнсний бараа, ундаа, ус	104.4	117.6	104
Согтуурах ундаа, тамхи	100.5	100.5	99.5
Хувцас, бөс бараа, гутал	102	102.9	100.3
Орон сууц, ус, цахилгаан, түлш	100.3	99.9	99.8
Гэр ахуйн тавилга, бараа	101.5	100.6	101.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	114.3	100	100
Тээвэр	112	108.7	105.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	101.5	100	100
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	119.6	100.2	100
Боловсролын үйлчилгээ	100	100	100
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	114.1	99.1	100
Бусад бараа үйлчилгээ	104.7	103.6	100.5

БАЯНХОНГОР АЙМГИЙН 2017 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН МАЛ ТӨЛЛӨЛТ, ТӨЛ БОЙЖИЛТЫН МЭДЭЭ

д/ д	Сумын нэр	Оны эхний хээлтэгч	Оны эхний хээлтэгчи д эзлэх хувь	Төллөсөн хээлтэгч					Гарсан төл						
				Бүгд	үүнээс				Бүгд	үүнээс					
					ингэ	гүү	үнээ	хонь		ямаа	ботг о	унаг а	тугал	хурга	ишиг
1	Баянхонгор	66740	49.0	32707	8	312	2430	12543	17414	32707	8	312	2430	12543	17414
2	Баацагаан	140705	81.2	114274	332	1168	1226	27571	83977	114274	332	1168	1226	27571	83977
3	Баянбулаг	50737	92.4	46892	2	690	1551	26321	18328	46900	2	690	1551	26329	18328
4	Баянговь	86389	62.4	53917	363	48	318	8732	44456	53917	363	48	318	8732	44456
5	Баянлиг	96519	60.0	57940	2460	85	73	10524	44798	57942	2460	85	73	10526	44798
6	Баян-Овоо	104198	74.8	77912	49	950	1196	40597	35120	77912	49	950	1196	40597	35120
7	Баян-Өндөр	70047	84.4	59137	709	213	93	9765	48357	59137	709	213	93	9765	48357
8	Баянцагаан	103554	90.0	93162	204	514	331	22980	69133	93162	204	514	331	22980	69133
9	Богд	92563	72.0	66630	921	27	572	12870	52240	66630	921	27	572	12870	52240
10	Бөмбөгөр	107190	78.1	83763	6	155	240	24762	58600	83763	6	155	240	24762	58600
11	Бууцагаан	118610	75.8	89851	262	613	689	25043	63244	89991	262	613	689	25073	63354
12	Галуут	105129	43.5	45687		110	341	24872	20364	45687		110	341	24872	20364
13	Гурванбулаг	60076	59.2	35591		175	1120	21192	13104	35591		175	1120	21192	13104
14	Жаргалант	62284	59.6	37119		680	3865	18235	14339	37150		680	3865	18266	14339
15	Жинст	86121	70.4	60621	233	275	184	14915	45014	60621	233	275	184	14915	45014
16	Заг	60730	83.1	50471	5	794	851	26444	22377	50471	5	794	851	26444	22377
17	Өлзийт	109152	60.1	65645	24	285	802	25279	39255	65645	24	285	802	25279	39255
18	Хүрээмарал	75860	68.3	51821	34	608	651	24172	26356	51821	34	608	651	24172	26356
19	Шинэжинст	74754	48.3	36091	551	13	7	5800	29720	36096	551	13	7	5800	29725
20	Эрдэнэцогт	69369	68.5	47492		204	6532	22160	18596	47492		204	6532	22160	18596
	ДҮН	174072	69.3	120672	616	791	2307	40477	76479	120690	6163	7919	2307	40484	76490
		7		3	3	9	2	7	2	9			2	8	7

Хорогдсон төл						Бойжсон төл					
Бүгд	үүнээс					Бүгд	үүнээс				
	ботго	унага	тугал	хурга	ишиг		ботго	унага	тугал	хурга	ишиг
675		12	26	283	354	32032	8	300	2404	12260	17060
199	2				197	114075	330	1168	1226	27571	83780
1048		43	79	435	491	45852	2	647	1472	25894	17837
577	4		5	18	550	53340	359	48	313	8714	43906
80					80	57862	2460	85	73	10526	44718
305		2	3	142	158	77607	49	948	1193	40455	34962
480	14			108	358	58657	695	213	93	9657	47999
0						93162	204	514	331	22980	69133
0						66630	921	27	572	12870	52240
0						83763	6	155	240	24762	58600
32	2			10	20	89959	260	613	689	25063	63334
280		12	21	112	135	45407	0	98	320	24760	20229
62		5	4	23	30	35529	0	170	1116	21169	13074
958		45	78	380	455	36192	0	635	3787	17886	13884
334				15	319	60287	233	275	184	14900	44695
252		2		55	195	50219	5	792	851	26389	22182
611	3	6	8	143	451	65034	21	279	794	25136	38804
0						51821	34	608	651	24172	26356
526				23	503	35570	551	13	7	5777	29222
564		7	46	155	356	46928	0	197	6486	22005	18240
6983	25	134	270	1902	4652	1199926	6138	7785	22802	402946	760255

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Хаяг: АЗДТГазар 303, 305 тоот
Холбоо барих утас: 70442081, 70442403

И мэйл хаяг: bayankhongor@nso.mn

Вэб сайт: www.nso.mn сайтын Баянхонгор /Статистикийн хэлтэс-Бюллетень/,

bayankhongor.gov.mn сайтын Статистик мэдээ мэдээлэл